

**ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА
ХҮМҮҮНЛЭГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН
БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

Нэг. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь сургалтын эрх чөлөөг хамгаалах, сургалт, судалгааны ажлын хамгийн дээд төвшний стандартыг хангахад туслах, үүний тулд багшийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүй (биеэ авч явах ёс зүй)-н хэм хэмжээ, зан үйлийг тогтоон хэвшүүлж, багшийн нэр төрийг хамгаалахад оршино.

1.2. Багшийн давуу эрх, ажиллах болон бусад баталгаа нь багшийн мэргэжлийн чадвар, сургалтын эрх чөлөө болон дээд боловсролын байгууллагын үндсэн үүргийн харилцан уялдаанд оршино. Энэ харилцаа нь багшийн мэргэжлийн хариуцлагын эх сурвалж болно.

1.3. Хүмүүнлэгийн дээд сургуулийн багш нь сургуулийнхаа нэр хүндийг ямагт өндөрт өргөн ХДС-ийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхдээ багш, оюутны үе үеийн залгамж холбоог дээдлэж, багшийн ёс зүйн үлгэр жишээг үзүүлнэ.

Хоёр. ДҮРМИЙН НЭР ТОМЪЁО

2.1. Энэ дүрэмд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "Багшийн мэргэжлийн ёс зүй" гэж багшийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой нийтээр хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшил, хэвшсэн соёл болон харилцааны үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

2.1.2. "Багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ" гэж багшийн мэргэжилдээ үнэнч байж, багш мэргэжлийн нэр хүндийг хамгаалж, хүлээсэн үүргээ чанд биелүүлэх талаар тогтоосон шаардлагын цогцыг хэлнэ.

2.1.3. "Багшийн ёс зүйн зөрчил" гэж энэ дүрмээр тогтоосон багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

2.1.4. "Сургалтын эрх чөлөө" гэж мэдлэг бүтээх, эзэмших, дамжуулах үйл явц хараат бус, ямар нэг нөлөөлөлд автаагүй, багш хичээлээ өөрийн арга барилаар заах, оюутан сонирхол, хэрэгцээндээ тохируулан боловсрол эзэмших нөхцлийг хангах боломж бүрдүүлэхийг хэлнэ.

Гурав. БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЭРХ

3.1. Дээд боловсролын байгууллага нь багш нарыг сургалт, судалгааны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангаж, дэмжих үүрэгтэй.

3.2. Дээд боловсролын байгууллага дүрмээрээ багшийн сургалтын эрх чөлөөг хангана.

3.3. Багш нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу доорх эрхээр хангагдана:

- 3.3.1. судалгаа, шинжилгээний ажлыг чөлөөтэй хийх, түүний үр дүнгийн талаар санал солилцох;
- 3.3.2. сургалтад шинжлэх ухааны дэвшилтэт аргыг сонгон хэрэглэх;
- 3.3.3. боловсролын стандартад нийцсэн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон хэрэглэх;
- 3.3.4. үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх;
- 3.3.5. хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах.

Дөрөв. БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ, МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГА

А. Багшлах үүргээ хэрэгжүүлэхэд тавих ёс зүйн хэм хэмжээ

4.1. Багш суралцагчдаа бүтээлчээр, бие даан суралцах чадвар эзэмшүүлэхэд анхаарч, суралцагч сурахын төлөө чөлөөтэй эрэл хайгуул хийхэд дэмжлэг үзүүлнэ. Багш хичээлээ мэргэжлийн өндөр төвшинд заана. Багш нь суралцагчдадаа хувь хүний нь хувьд хүндэтгэл үзүүлэн тэднийг сурах үйл ажиллагааг чиглүүлэн удирдагч, зөвлөгч байх ёстой. Багш нь суралцагчийн мэдлэг чадвар, хүчин чармайлтыг бодитой, шударга үнэлдэг байна. Багш, суралцагч хоорондын харилцаанд итгэл, хүндэтгэлийг эрхэмлэнэ. Суралцагчийг дарамтлах, ялгаварлан гадуурхахаас зайлсхийнэ.

4.2. Багшлах үйл ажиллагааны зохисгүй хэлбэрүүд:

4.2.1. Багшлах үүргээ биелүүлэхгүй байх;

4.2.1.1. суралцагчийг дур зоргоороо хичээлд оруулахгүй байх;

4.2.1.2. хичээлд холбогдолгүй материалыг сургалтад ихээр ашиглах;

4.2.1.3 хичээл, шалгалт болон ажлын цагийн хуваарийг зохицуулсан журмыг зөрчих;

4.2.1.4. суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг тухайн хичээлд шууд хамааралгүй шалгуураар дүгнэх;

4.2.1.5. суралцагчийн сургалтын үр дүнг үнэлэхийг шалтгаангүйгээр буюу тодорхойгүй хугацаагаар дур мэдэн хойшлуулах.

4.2.2. суралцагчийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн онцлог болон хувийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, тэдэнд тэгш бус хандах;

4.2.3. албан тушаал буюу эрх мэдлээ ашиглан дур мэдэн эсхүл хувийн шалтгаанаар суралцагчийн санал бодол, ухамсарт хүчээр нөлөөлөх, үзэл бодлоо тулгах, аашилж загнах, айлган сүрдүүлэх зэргээр зүй бус авирлах;

4.2.4. өөрийн болон бусдын бичсэн ном зохиол, бичмэл материалыг суралцагчдад тулган зарж, борлуулах.

Б. Багшийн мэдлэг, боловсролд тавих ёс зүйн хэм хэмжээ

4.3. Багш мэдлэг, боловсролоо тасралтгүй дээшлүүлж байхын үнэ цэнэд тулгуурласан өөрт оногдох тусгай хариуцлагыг хүлээн зөвшөөрнө. Багшийн заах хичээлтэй холбоотой үндсэн хариуцлага нь үнэнийг бусдын эрхшээлд авталгүй хайж, түүнийг батлах явдал мөн. Үүний тулд багш нар мэдлэг, боловсрол, заах арга, судалгаа хийх чадвараа хөгжүүлэн сайжруулахын төлөө өөрийн хүчээ дайчилна. Багш сургуулиас гадуур хийх мэргэжлийн үйл ажиллагаанд байгууллагынхаа тавих шаардлагыг биелүүлнэ.

4.4. Ёс зүйн зохисгүй хэлбэр:

4.4.1. Багш бусдын зохиол бүтээл, судалгаа, нээлтийг санаатайгаар хууль бусаар өөрийн болгох байдлаар нийтээр хүлээн зөвшөөрсөн оюун санааны цэвэр ариун байх ёс дэгийг зөрчих.

В.Сургалтын байгууллагын ажилтны хувьд тавих ёс зүйн хэм хэмжээ

4.5. Дээд боловсролын байгууллагын багш бүтээлч байж, ажил үүргээ мэргэшлийн өндөр төвшинд санаачлагатай, шударгаар биелүүлэх ёстой. Багш сургуулийнхаа дүрэм, дотоод журмыг баримталдаг байна. Багш ажил үйлчилгээгээ түр буюу бүр мөсөн зогсоох тохиолдолд сургуулийн хөтөлбөрийн хэрэгжилтэд энэ шийдвэр хэрхэн нөлөөлөхийг ухамсарлаж, холбогдох албан тушаалтанд урьдчилан мэдэгддэг байна.

4.6. Ёс зүйн зохисгүй хэлбэрүүд:

- 4.6.1. сургуулиас санаачилсан буюу зохион байгуулсан ажил, үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулах;
- 4.6.2. зөвшөөрөлгүйгээр сургуулийн нөөц буюу тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хувийн болон арилжаа, улс төр, шашны зорилгоор ашиглах;
- 4.6.3. сургуулийн багш, ажилтан, бусад хүмүүсийн үүрэгт ажлаа гүйцэтгэхэд нь саад учруулах, заналхийлэх буюу дарамтлах;
- 4.6.4. багшийн мэргэжлийн ёс зүйн талаар сургуулиас баримталж буй бодлогыг зөрчих;
- 4.6.5. ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, ажилдаа согтуу ирэх;
- 4.6.6. хувийн үзэл бодлоо санаатайгаар сургууль, түүний нэгжийн байр суурь хэмээн ойлгуулах.

Г. Хамт ажиллагсадтайгаа харилцахад тавих ёс зүйн хэм хэмжээ

4.7. Хамт ажиллагчидтай хүндэтгэлтэй харилцаж, ажил төрлийн холбогдолтой бодитой шүүмжлэл, санааг хүлээн авч, аливаа маргаан зөрчлийг эв зүйгээр шийднэ. Хамт ажиллаж байгаа хүмүүсийн судалгаа шинжилгээ хийх эрх чөлөөг хүндэтгэнэ, Шүүмжлэл, санал бодлоо солилцоходоо бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандана. Багш сургалтын үүргээ ухамсарлан хамтран ажиллагчдынхаа талаар мэргэжлийн дүгнэлт өгөхдөө бодитой хандах ёстой. Багш оногдсон эрх, үүргийнхээ дагуу сургуулиа удирдах хэрэгт өөрийн оролцоог хангана.

4.8. Ёс зүйн зохисгүй хэлбэрүүд:

- 4.8.1. мэргэжлийн үйл ажиллагаанд шууд холбогдохгүй шалгуураар багшийн мэргэжлийн чадварыг үнэлэх;
- 4.8.2. хувь хүний нууцыг хамгаалсан хууль тогтоомжийг зөрчих;
- 4.8.3. бусад багшийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн онцлог болон хувийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, тэдэнд тэгш бус хандах.

Тав. САХИЛГЫН ШИЙТГЭЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ

5.1. Багш мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд түүнд сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

5.2. Сургуулийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцэн баталгаажуулсан энэхүү багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн багшид сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг ХДС-ийн дотоод журам болон энэхүү журмын хүрээнд ХДС-ийн Багшийн мэргэжлийн ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.3. Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд тухайн багшид сахилгын шийтгэл ногдуулахааргүй бол Захирлын тушаалаар сануулах, хөдөлмөрийн гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авах бөгөөд ажил тасалсан бол цагийн хөлсийг цалингаас нь суутгана.

5.4. Багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн багшид сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг сургалтын байгууллагын холбогдох тэнхим, салбар сургууль судлан, санал боловсруулна. Шаардлагатай үед мэргэжлийн ёс зүйн зөвлөлийн хурлын протоколыг үндэслэн Захирлын тушаалаар захиргааны арга хэмжээ авна.

Зургаа. БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАГАА

6.1. Сургууль нь багшийн мэргэжлийн Ёс зүйн зөвлөлтэй байна. Ёс зүйн зөвлөл нь багшийн гаргасан ёс зүйн зөрчлийг хэлэлцэх, багшийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол, өргөдөл, мэдээлэл хүлээн авах, барагдуулах, ёс зүйн хэргийн нотолгоо, баримтыг шинжлэн судлах, сахилгын шийтгэл ногдуулах эсэх үндэслэлийг шалган тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.2. Ёс зүйн зөвлөл нь багшийн ёс зүйн дүрмийн хүрээнд ажлаа явуулах бөгөөд шаардлагатай үед оюутны ёс зүйн дүрмийн биелэлтэд хяналт тавьж байх Оюутны Ёс зүйн хороотой хамтран ажиллана.

6.3. Багшийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн дагуу арга хэмжээгээр шийтгэгдсэн тооцогдсон багш нь хариуцлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй гэж үзвэл ХДС-ийн мэргэжлийн ёс зүйн зөвлөлд хандах эрхтэй. Багшийн эрхийг хамгаалах үүднээс Ёс зүйн зөвлөл нь асуудлыг дахин хэлэлцэх, тайлбарыг нь сонсох зэргээр заавал хэлэлцэн шударга ажиллаж зохих шийдвэрийг гаргана.

6.4. Багшийн мэргэжлийн Ёс зүйн зөвлөлийн гишүүнийг Захиргааны зөвлөлийн хурлаас ил санал хураалтаар сонгоно.

6.5. Багшийн мэргэжлийн Ёс зүйн зөвлөлийн гишүүдийн тоо 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

6.6. Багшийн мэргэжлийн Ёс зүйн зөвлөлийн даргыг сонгогдсон гишүүдийн хурлаар нууц санал хураалтаар сонгоно. Дарга нь багшийн мэргэжлийн Ёс зүйн зөвлөлийн бичиг баримтыг зохих бланкаар үйлдэнэ.

6.7. Багшийн мэргэжлийн Ёс зүйн зөвлөлийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хийнэ. Ёс зүйн дүрмийг зөрчсөн багшийн асуудлыг хурлаараа хэлэлцэхдээ зөрчил гаргасан багшийг байлцуулна. Уг хурлаас багшид холбогдох асуудлыг сургуулийн дотоод журам, энэхүү дүрмийн хүрээнд хэлэлцэн шийдвэр гаргаж тэмдэглэгээгээр батална. Хурлаас гаргасан санал, зөвлөмж, арга хэмжээг багшид мэдэгдэж шаардлагатай бол сургуулийн захиргаанд өгнө. Хурлыг ил тод, шударга зарчмаар явуулна.

6.8. Багшийн мэргэжлийн Ёс зүйн зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрөөгүй багш иргэний журмаар Иргэний хуулийн хүрээнд асуудлаа шийдүүлэх эрх нь нээлттэй байна. Багшид ногдуулсан сахилгын шийтгэл нь сахилгын зөрчлийн үр дагаварыг арилгасны дараа буюу шийтгэгдсэн багшийг шийтгэлгүйд тооцох, шийтгэлийг хөөн хэлэлцэх хугацаа нь хичээлийн жилийн нэг улирал байна.